

# ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАН *2012-2014*

Глоб Интернэшнл Төв



Нэгдсэн Үндэстний  
Боловсрол, Шинжлэх Ухаан  
Совёлын Байгууллага

ЮНЕСКО-гийн  
Бээжин дэх  
Төлөөлөгчийн газар

*Энэ тайланг хэвлэхэд дэмжлэг үзүүлсэн ЮНЕСКО-гийн Бээжин дэх  
Төлөөлөгчийн газарт гүн талархал илэрхийлье.*



Мэдлэг бол - Хүч

**Хаяг:** Чингэлтэй дүүрэг, IV хороо,  
Дипломат 95 цогцолбор,  
3-р орц, 32 тоот  
ш/х 102, Монгол улс

**Утас:** 976-11-324627,  
976-11-324764

**Факс:** 976-11-324764

**Э-шуудан:** [globenews@globeinter.org.mn](mailto:globenews@globeinter.org.mn),  
[globemon@gmail.com](mailto:globemon@gmail.com),  
[hnanan@globeinter.org.mn](mailto:hnanan@globeinter.org.mn),

**Вэбсайт:** [www.globeinter.org.mn](http://www.globeinter.org.mn)

# ГАРЧИГ

<b>ӨМНӨТГӨЛ .....</b>	<b>4</b>
<b>НЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ .....</b>	<b>6</b>
1.1. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАТАЛГАА .....	6
1.2. ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА СЭТГҮҮЛ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	7
1.3. МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ.....	8
1.4. СОНГУУЛЬ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ .....	9
1.5. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ, ТҮҮНИЙ ХЯГААРЛАЛТУУД.....	10
1.6. МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ЭРХИЙН ХЯЗГААРЛАЛТ .....	10
1.7. НЭР ТӨР ГУТААХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖ .....	11
1.8. АГУУЛГЫН ХЯЗГААРЛАЛТ .....	12
1.9. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ .....	13
<b>ХОЁР. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЗӨРЧИЛ 2012-2014 ОНД .....</b>	<b>18</b>
<b>ГУРАВ. СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭСРЭГ ИРГЭНИЙ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ .....</b>	<b>23</b>
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>26</b>

# ӨМНӨТГӨЛ

Жил бүрийн тавдугаар сарын гуравны өдөр тэмдэглэдэг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан манай байгууллагаас 2012-2014 оны хэвлэлийн эрх чөлөөний тайлангаа та бүхэнд өргөн барьж буйдаа таатай байна.

Хэвлэлийн Хүрээлэнгийн 2014-2015 оны судалгаагаар Монгол Улсын хэмжээнд 421 хэвлэл мэдээллийн хэрэгсэл тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 136 телевиз, 71 радио, 122 сонин, 92 сэтгүүлд нийт 4400 орчим хүн ажиллаж байна. 2014 оны эхний улирлын байдлаар 71 цахим хэвлэл мэдээллийн вэбсайт бүртгэгджээ.

Мэдээлэл харилцааны шинэ технологи хөгжихийн хэрээр цахим хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь хэвлэл мэдээллийн салбарт шинэ шинэ сорил, бэрхшээлийг дагуулах болов. Энэ нь цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх, хувийн нууц, ёс зүй, хүртээмжтэй байдал, цахим аюулгүй байдал зэрэг олон асуудлын тухай олон талыг оролцуулсан, нийгмийн илүү цогц яриа хэлэлцүүлгийг шаардах болжээ. Интернэтийн өөрийн мөн чанар, мэдээлэл, мэдлэгээ солилцох, хуваалцах боломж, хэрэглэгчийн үүсгэх агуулгын хэмжээ, багтаамжийг агуулсан нийтлэг шинжүүд, хэрэглэгчдийн үйлдэл, нийтийн талбарт үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх соёл, дадал, хэвшил нь нийгмийн харилцааны гол асуудлуудыг олон талаас нь шүүн ярилцах шаардлагатайг харуулж байна. Аливаа асуудалд хандахдаа нээлттэй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэх үүднээс асуудалд хандахыг НҮБ байнга уриалж байдаг. Харамсалтай нь, Харилцааны холбооны зохицуулах хорооны (ХХЗХ)-ны ерөнхий нөхцөл шаардлага, бусад дүрэм журам нь шүүлтүүр хэрэглэх, мэдээ, мэдээллийн цахим хуудсыг бүртгэх, тусгай зөвшөөрөлтэй болгох зэргээр НҮБ, олон улсын хэм хэмжээг зөрчиж, иргэдийн цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэтрүүлэн хязгаарлах болсон нь тайланд дурдсан жилүүдийн онцлох асуудал юм.

2012-2014 онд манай байгууллагын бүртгэснээр сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх оролдлого хийх, дарамт шахалт үзүүлэх, сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх, заналхийлэх, мэдээлэл олж авах, түгээхэд нь саад хийх, нууц эх сурвалжаа илчлэхийг албадах, хүчний байгууллагуудаас, ялангуяа Тагнуулын Ерөнхий газраас сэтгүүлчдийг олноор байцаах, мэдүүлэг авах, улс төрч, төрийн байгууллага болон нийтийн албан тушаалтнууд Эрүүгийн хуулийн зүйл заалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн дуу хоолойг боомилох цензур болгон ашиглах зэрэг зөрчил урд жилүүдтэй харьцуулахад нэмэгдсэн нь түгшүүр төрүүлж байна.

Та бүхэнд толилуулж буй уг тайлангийн эхний бүлэгт бид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн хүрээ, тухайлбал түүний баталгаа, хязгаарлалтын талаар танилцуулж, хоёр дахь бүлэгт 2012-2014 онд хэвлэлийн эрх чөлөөний талаарх онцлох мэдээлэл, гурав дахь бүлэгт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг иргэний болон эрүүгийн хэргийн харьцуулсан судалгааг багтаасан болно.

Энэ жилийн Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр нь хоёр үйл явдалтай давхцаж буйгаараа ач холбогдолтой юм. Нэгдүгээрт, Монгол Улс “Онлайн эрх чөлөө” эвсэлд нэгдэж, 2014-2015 онд тус Эвслийг тэргүүлж буйн хувьд Эвслийн орнуудын сайд нарын V бага

хурлыг Улаанбаатар хотноо 2015 оны 5 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд зохион байгуулна. Хоёрдугаарт, тавдугаар сарын 5-ны өдөр Женев хотноо НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын үндэсний илтгэлийг хэлэлцэх гэж байна. Монголын Хүний эрхийн төрийн бус байгууллагын Форумаас хүний эрхийн 12 сэдвээр тайлан бичиж, илгээсний дотор манай байгууллага “Үзэл бодлын эрх ба түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө”<sup>1</sup> сэдвээр тусгайлсан тайлан бэлтгэсэн билээ. Энэ тайланг та бүхэн хавсралтаас бүрэн эхээр нь үзэж болно.

Монгол Улсын УИХ, Засгийн газар ирэх жилийн Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг өнөөдөр үйлчилж буй хууль тогтоомж, дүрэм журмаа 1974 онд соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд нийцүүлэн өөрчилсөн сайхан мэдээгээр угтана гэдэгт итгэж байна. Бид Үндсэн хуульдаа заасан “Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэдгээ Тунхаглан зарласан билээ.

Та бүхэн уг тайлангийн талаар санал зөвлөмжөө [globe@globeinter.org.mn](mailto:globe@globeinter.org.mn), [globenews@globeinter.org.mn](mailto:globenews@globeinter.org.mn) цахим хаягаар илгээнэ үү. Бид та бүхний үнэтэй санал зөвлөмжийг дараагийн тайландаа онцгойлон анхаарах болно.

Глоб Интернэшнл Төвийн тэргүүн Х.Наранжаргал

---

<sup>1</sup> <http://upr-mongolia.mn/images/10FreedomsofopinionandexpressionUPRmong.pdf>

# НЭГ. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ

## 1.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

### Үндсэн хууль ба олон улсын эрх зүйн хэм хэмжээ

Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээн заасан. Үүнд:

16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.

16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

Монгол Улс НҮБ-д 1961 онд гишүүнээр элсэн орсон бөгөөд гишүүн орны хувьд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг соёрхон баталж, 2012 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элссэн. Тиймээс олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй. Энэ үүргийг Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. Эдгээр олон улсын гэрээ конвенци 2005 онд “Төрийн мэдээлэл” сэтгүүлд монгол хэлнээ албан ёсоор хэвлэгдсэн.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэжээ.

2011 оны 7 дугаар сарын 11-29-ний өдрүүдэд Женев хотноо болсон НҮБ-ын Хүний эрхийн хорооны 102 дугаар чуулганаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд 34 тоот Ерөнхий тайлбарыг баталсан нь уг зүйл заалтын хэрэглээг илүү тодорхой болгосон.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17 дахь хэсэгт “Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” хэмээн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тавьж болох зорилго, үндэслэлийг заасан.

## 1.2. Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа

1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр УИХ-аас “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хууль баталсан юм. Уг хуулийн 2 дугаар зүйлээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон. Мөн 3 дугаар зүйлд “төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглож, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ”, 4 дүгээр зүйлд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэж заасан нь хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан суурь зохицуулалт болдог.

Улсын Дээд Шүүх (УДШ)-ийн тайлбарт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэдгийг “Зар сурталчилгааны тухай” хуулийн 3 дугаар бүлэгт 3.1.5 дахь хэсэгт “Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно хэмээн тогтоосон.

УИХ-аас 2005 оны 1 дүгээр сарын 27-нд “Олон нийтийн радио, телевизийн тухай” хууль баталснаар үндэсний хэмжээнд олон нийтэд үйлчлэх, түүний хяналт санхүүжилтэд байх статус бүхий телевиз, радиогийн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Түүнээс хойш хэвлэл мэдээллийн салбарт шаардлагатай байгаа өргөн нэвтрүүлгийн ерөнхий хууль, сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах, мэдээлэгчийг хамгаалах, салбар дахь шударга өрсөлдөөн, өмчлөлийн ил тод байдлыг хангах тухай эрх зүйн зохицуулалт хийгдээгүй.

2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлээр сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийх нь гэмт хэрэг гэж үзсэн. Уг 139 дүгээр зүйлд УДШ-ээс 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдөр 51 дугаар тогтоолоороо албан ёсны тайлбар хийсэн. Энд “Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээлэл...” гэдэгт тухайн этгээдийн өөрт нь болон бусдад холбоотой тодорхой асуудал, сэдвийн дагуу нийтэд мэдээлэхээр сэтгүүлчээс бэлтгэсэн аливаа бүтээлийг ойлгоно”, “...сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаа...” гэж Үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг хайх, хүлээн авах, цуглуулах, боловсруулах, нийтлэх ажиллагааг хэлнэ”. Хуулийн заалтын энэ томъёолол болон тайлбарын дагуу сэтгүүлчийн үйл ажиллагааг хамгаалж чадахгүй байна.

2014 оны 7 дугаар сарын 4-ний өдөр УИХ-ын гишүүн М.Батчимэгийн ахалсан ажлын хэсгийн гишүүд Хэвлэлийн эрх чөлөөний хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан.

2000 онд батлагдсан Монгол Улсын “Хүний Эрхийн Үндэсний Комиссийн тухай” хуулиар “Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих байгууллага мөн” (3.1 дүгээр зүйл). Комисс нь 2001 онд байгуулагдсанаасаа хойш хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол саналыг хүлээн авч, шийдвэрлэж байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ” (3.3.3.2) гэж заажээ. Түүнчлэн “хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана” (3.3.4.3) гэж заасан байдаг.

### 1.3. Мэдээлэл авах эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.17 дугаар зүйлд мэдээлэл “хайх, хүлээн авах” эрхийг хамгаалдаг бөгөөд мэдээлэл “түгээх” эрхийн тухай үгчлэн оруулаагүй хэдий ч өмнө дурдсан олон улсын гэрээ конвенцийн дагуу “хил хязгаар үл харгалзан<sup>2</sup>” мэдээлэл “хайх, хүлээн авах болон түгээх” эрх баталгаажсан гэж үздэг.

2005 онд батлагдсан Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 34.1 зүйлд “Олон нийтийн радио, телевизийн ажилтан төр, байгууллага болон хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг олж авах, нийтийн хүртээл болгох эрхтэй” гэж МҮОНРТ-ийн сэтгүүлчдийн эрхийг баталгаажуулсан. Харин 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай (МИТБМАЭ) хууль батлагдсанаар мэдээлэл олж авах эрхээ эдлэх боломж, нөхцөл хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид төдийгүй иргэдэд бүрдсэн.

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлд үйл ажиллагаа, төсөв, санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны мэдээллийг нээлттэй байлгах үүргийг төрийн байгууллагуудад ногдуулсан. Аливаа иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагаас хүссэн хэлбэрээрээ мэдээлэл авах хүсэлт гаргах эрхтэй бөгөөд төрийн албан хаагчид хүсэлтийн хариуг дээд тал нь ажлын 7 хоногийн дотор, зайлшгүй тохиолдолд ажлын 14 хоногт өгөх үүрэгтэй. Хариуг нь шууд өгөх боломжтой хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж хариу өгнө.

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан өгөхийг хориглосон мэдээллийн төрөл нь хэт ерөнхий, өргөн хүрээг хамарч байна. Үүнд: (1) тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа бол (18.1.1), (2) тухайн мэдээлэл нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хянан шалгагдаж байгаа асуудалтай холбоотой бол (18.1.2), (3) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай (18.1.3) зэрэг тохиолдлууд орно. Түүнчлэн уг хууль нь оюуны өмч (19 зүйл), хувь хүний нууц (20 зүйл) болон байгууллагын нууцыг (21 зүйл) хамгаалдаг. Мөн хуулинд оюуны өмчтэй холбоотой мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно. (19.1 зүйл)

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 17 дугаар зүйлд эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд гомдол гаргах тогтолцоог оруулсан байна. Тэд дээд албан тушаалтан, дээд шатны байгууллага болон Хүний Эрхийн Үндэсний Комисс, Захиргааны шүүхэд гомдол гаргаж болно.

Уг хуулийн дагуу Засгийн газраас 2013 оны 1 дүгээр сард “Мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам”, 12 дугаар сард “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ыг тус тус баталсан.

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйл “Төсөв, санхүүгийн ил тод байдал”, 10 дугаар зүйл “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал” заалтуудыг хүчингүй болгож, 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон Шилэн дансны тухай хуульд эдгээр заалтуудыг оруулсан нь зарим байгууллагын мэдээлэл нээлттэй, ил тод болох асуудлаар эргэлзээтэй байдал бий болгов.

Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх үүрэг хүлээж, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим

<sup>2</sup> ИБУТЭТОУП-ын 19-р зүйл (2)



хаягийг байршуулсан байхаар заасан учир 5.000.000 /таван сая/ төгрөгөөс дээшхи гүйлгээ бүр ил тод болж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийтийн албан тушаалтнууд ашиг сонирхлын мэдүүлгээ, Авлигын эсрэг хуулиар өөрийн болон гэр бүлийнхээ хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлэх үүрэг хүлээсэн тул энэ төрлийн мэдээлэл нээлттэй болж байна.

## 1.4. Сонгууль ба хэвлэл мэдээлэл

“Сонгуулийн төв байгууллагын тухай”<sup>3</sup> хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар сонгуулийн үеэр Хэвлэл мэдээллийн зөвлөл ажиллахаар болов. “Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэл, мэдээллийн мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл болон сонгуульд оролцож буй нам, эвслийн тэгш төлөөллөөс бүрдсэн байна” /14.2/, “Хэвлэл мэдээллийн зөвлөл нь нам, эвсэл, нэр дэвшигчийн хэвлэл мэдээллийн сурталчилгааны тэнцвэрт байдалд хяналт тавих бөгөөд энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, хуулийн этгээд, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, санал дүгнэлт гаргаж Хороонд танилцуулах чиг үүрэгтэй” /14.3/ гэж заасан ч өмнөх сонгуулиудын үеэрх үр дүнтэй зохицуулалтын механизм болж чадаагүй.

2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдөр “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга тус тус батлагдсан. Энэ хуулийн “Сонгуулийн сурталчилгаа” хэмээх 35 дугаар зүйл нь хэвлэл мэдээлэлтэй холбоотой. Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт “Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээх үүрэгтэй”-г заасан. Үүнийг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллага, албан тушаалтныг торгоно.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйл, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд сонгуулийн сурталчилгааг УИХ-ын сонгуулийн үеэр сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт 2 цагаас, Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хоногт 1 цагаас илүүгүй байхаар, түүнчлэн нэр дэвшигч бүрт ижил нөхцөл, боломж, тэнцүү хугацаа ногдохоор тооцох бөгөөд сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш сурталчилгааны хуваарь, цагийг бусад нэр дэвшигчдэд шилжүүлэхийг хориглосон, улс төрийн чансаа тогтоох зорилгоор аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулахыг хориглосон байна. УИХ-ын сонгуулийн хуулийг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор хуульд заасан.

Түүнчлэн “Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай” хуулинд ШӨХТГ-ын дүгнэлтээр ХХЗХ нь хууль зөрчсөн өргөн нэвтрүүлгийн байгууллагын тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх /39.10 зүйл/ эрх олгосноор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн аливаа хэлбэрийн цагдан хяналт тавих, ийм байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй зэрэг хуулийн заалтууд зөрчигдөж, хэвлэл мэдээлэлд төрийн цагдан хяналт тогтоож байна.

Сонгуулийн ерөнхий хороо сонгууль явуулах жил бүр “Сонгуулийг ажиглах, сурвалжлах журам”-аа шинэчлэн баталдаг.

Монгол Улсын сонгуулийн бүх хууль гүтгэлэг, доромжлолыг хатуу хориглосон заалтууд байгаа нь илүүц хязгаарлалт болж байна.

<sup>3</sup> 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан

## 1.5. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүний хязгаарлалтууд

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэж заасан. Итгэл үнэмшилтэй байвч түүнийгээ илэрхийлэх арга хэрэгсэлгүй бол энэ эрх хэрэгжих боломжгүй юм.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарим хязгаарлалтыг Үндсэн хуулийн үзэл баримтлал болон олон улсын гэрээ конвенцийг удирдлага болгож, Гурван талт шалгуур /Three part test/-ыг бүрэн хангасан үед л зөвхөн хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнд:

Нэгдүгээрт. Гагцхүү хуулиар тогтоох

Хоёрдугаарт. Хязгаарлалт нь хууль ёсны зорилготой байх

Гуравдугаарт. Зайлшгүй буюу гарцаагүй байх, хэмжээндээ байх

Үүнээс өөрөөр хязгаарлалт хийхийг хүлээн зөвшөөрөх ёсгүй ч, илүүц, хүний язгуур эрхийг зөрчсөн хязгаарлалтууд хийгдсээр байна.

## 1.6. Мэдээлэл олж авах эрхийн хязгаарлалт

МИТБМАЭ-ийн тухай хууль батлагдсаны дараа Төрийн нууц, Байгууллагын нууц болон Хувь хүний нууцын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт ороогүй. Эдгээрээс гадна бусад олон хуульд нууцлалын тухай зүйл заалтууд байдаг. 2013 оны 1 дүгээр сард УИХ-аар “Төрийн нууцын жагсаалтын тухай” хуулийн төслийг хэлэлцсэн боловч батлаагүй.

“Төрийн нууцын тухай хууль” 1995 онд батлагдаж, хамгийн сүүлд 2004 оны 1 дүгээр сарын 2-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар “Төрийн нууцыг задруулснаас Монгол Улсын ашиг сонирхол, аюулгүй байдалд учирч болох хор уршгийн хэмжээнээс хамааран төрийн нууцын зэрэглэлийг тогтооно” гэсэн бөгөөд төрийн нууц нь онц чухал-маш нууц, маш нууц, нууц гэсэн гурван зэрэглэлтэй байна.

Энэ хуулиар төрийн нууцыг үндсэн 5 төрөлд ангилдаг. Мөн “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуулиар 60 зүйлээр мэдээллийг, тухайлбал үндэсний аюулгүй байдлын хүрээнд 19, батлан хамгаалах хүрээнд 14, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, технологийн хүрээнд 5, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд 15, бусад хүрээнд 7 зүйлийн мэдээллийг нууцлахаар тогтоожээ. Нийт мэдээллийн 70 хувийг 40-60 жилээр, эсвэл байнга нууцалсан байна.

Эрүүгийн хуулийн 87.1 дүгээр зүйлд “төрийн нууц задруулах” гэмт хэргийн тухай заасан. Үүнд “Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, 87.2 дугаар зүйлд “Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан байдаг.

“Байгууллагын нууцын тухай” хуулиар байгууллага нь нууцаа хамгаалах журмыг өөрөө тогтоож мөрдөнө гэж заасан /5.1/. Хуулийн 6 дугаар зүйлээр тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл бол, мөн тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээллийг нууцлахыг хоригложээ. Мөн гэмт

хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг байгууллага нууцалж болохгүй.

Дээрх хуулийн заалтууд нь ерөнхий, нарийвчлал байхгүйгээс сэтгүүлчдэд мэдээлэл өгөхөөс татгалзах, аливаа эрэн сурвалжилсан нийтлэл, нэвтрүүлгийн эсрэг хуулийн хязгаарлалтыг төрийн цензур болгон ашиглахад хүргэж байна.

## 1.7. Нэр төр гутаахтай холбоотой хууль тогтоомж

Монгол Улсад иргэний нэр төрийг Иргэний болон Эрүүгийн хуулиар хамгаалдаг. Төрийн, төрийн бус, бизнесийн болон бүхий л төрлийн байгууллагууд эдгээр хуулийг ашиглан нэр төр, алдар хүндээ сэргээлгэх боломжтой. Монгол Улсын Эрүүгийн хуулинд зааснаар “гүтгэлэг, доромжлол”-ыг гэмт хэрэг гэж үзэх ба “доромжлох” (110 зүйл) ба “гүтгэх” (111 зүйл) заалтууд нь зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 2-5 жил хүртэл хугацаагаар хорих ял ноогдуулна. Тус хуулийн 231 дүгээр зүйлд заасны дагуу төрийн албан хаагч болон хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжилсон бол 1-3 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. Уг хуулиар “төрийн албан хаагч” гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно.

Эрүүгийн хуулийн эдгээр зүйлд Улсын Дээд шүүхээс 2007 оны 10 дугаар сарын 29-нд тайлбар гаргаж, нэр төр, алдар хүнд, доромжлох, гутаах зорилго, худал гүжирдлэг, олон нийт, урьд ял шийтгүүлсэн гэх мэт дээрх зүйлд дурдагдсан нэр томъёог тайлбарлажээ.

Иргэний хуульд Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах зохицуулалтууд байдаг. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд /21.1/ иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглоно хэмээн заасан. Уг хуулиар иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй (21.2 зүйл), бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан (21.3) бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.

Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээ (21.4), Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад (21.5) хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлд зааснаар “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөнд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй”.

Мөн хуулийн 511 дүгээр зүйлд зааснаар “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ”.

Нэр төр сэргээлгэх тухай Иргэний хуулийн зохицуулалтын нэг асуудалтай тал нь нийтийн албанд хамаарах байгууллагад нэр төр сэргээх боломж олгодогт байна. Өөр нэг тулгамдсан асуудал нь, Иргэний хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан бол түүнийхээ “бодитой”, “үнэн зөв” гэдгийг нотлохыг мэдээ тараагчид ногдуулсан. Энэ заалт нь хариуцагчид ихээхэн үүрэг ногдуулж байгаа бөгөөд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах нөлөө үзүүлж байна.

2011 оны 3 дугаар сарын 14-нөөс 21-ний өдрүүдэд АНУ-ын Нью-Йорк хотод болсон НҮБ-ын Хүний эрхийн хороо /101 дүгээр хуралдаан/-ноос Монгол Улсын Засгийн газарт хандан “Нэр төр, алдар хүндэд халдсан хэргийг эрүүгийн гэмт хэргээс хасч, сэтгүүлчийг аливаа сүрдүүлэг заналхийлэл, халдлагаас хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авах. Сүрдүүлэг заналхийлэл, халдлагын аливаа тохиолдлыг хуулийн дагуу мөрдөн шалгаж, гэмтэнд хариуцлага хүлээлгэхэд Оролцогч улс анхаарах<sup>4</sup>” гэсэн зөвлөмж өгсөн.

## 1.8. Агуулгын хязгаарлалт

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх, Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай зэрэг олон хуульд агуулгын хязгаарлалтыг тогтоосон. Эдгээр хязгаарлалт нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хийгдсэнийг бид хүлээн зөвшөөрч байгаа боловч нэр томъёоны хувьд ерөнхий, тодорхойлолт байхгүй, хамрах хүрээг нь тогтоогоогүй нь хэтрүүлэн ашиглах нөхцөл үүсгэж болзошгүй бөгөөд шүүмжлэл өрнүүлсэн сэтгүүлдэд халгаатай заалт болж байна.

ХХЗХ нь 2011 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”, “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ыг баталж, 2011 оны 3 дугаар сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн ба 2013, 2014 онуудад нэмэлт өөрчлөлт оруулан, агуулгын зохицуулалтыг хийсээр байна. Эдгээр хэм хэмжээний актууд нь Хууль зүйн яамны нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй байна. Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журамд зааснаар “улсын бүртгэлд бүртгэгдээгүй шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж үзэж тухайн шийдвэрийг биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага хүлээлгэхгүй” тухай заасан байдаг. Гэсэн хэдий ч эдгээр нөхцөл шаардлагууд нь хүчин төгөлдөр мөрдөгдөн, радио телевиз, цахим хуудасны агуулгад хяналт тавьж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, хандалтыг хаах зэрэгт үндэслэл болгон хэрэглэж байна.

Одоогоор сонин хэвлэлийн агуулгын зохицуулагч байхгүй. Радио, телевизийн хувьд “нийтийн эрх ашгийг” дээдлэх (5.1) үүрэг ногдуулж, долоо хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 50-иас доошгүй хувь нь Монгол Улсад бүтээгдсэн эсхүл Монгол Улсын иргэн, Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн бүтээсэн нэвтрүүлэг” (5.4) байхаар заажээ.

Сүүлийн үед УИХ-аас батлагдан гарч буй хууль, хэлэлцүүлгийн шатанд яваа хуулийн төслүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үүрэг ногдуулах, илүүц хязгаарлалт, хориг тавих, үүгээр дамжуулан төрийн байгууллагууд цагдан хяналт тогтоох эрсдэл нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, Соёлын тухай хуульд 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан нь 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх юм. Энэ өөрчлөлтөөр “Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт” гэсэн (19) зүйлд нэмэлт оруулсан. Энэ зохицуулалтын гол агуулга нь үндэсний нэвтрүүлгийг дэмжих төрийн бодлоготой уялдаж байгаа ч, хатуу хязгаарлалт болгон ашиглаж байгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт учруулж болзошгүй үүрэг ногдуулалт гэж үзэж болох юм.

<sup>4</sup> [http://www.ccprcentre.org/doc/HRC/Mongolia/CCPR.C.MNG.CO.5\\_en.pdf](http://www.ccprcentre.org/doc/HRC/Mongolia/CCPR.C.MNG.CO.5_en.pdf)

Монгол Улсад эдгээр агуулгын хяналтыг ШӨХТГ, Оюуны өмчийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, цагдаа, шүүх, тагнуулын байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар төрийн байгууллагууд хийж буй нь хэвлэл мэдээлэлд төрийн цензур байгааг нотолж байна.

## 1.9. Бусад зохицуулалт

### Хэвлэл мэдээллийн өмчлөл ба төвлөрөл

Монгол Улсад хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл олон төрөлтэй хэдий ч хуулиндаа өмчлөлийн олон талт байдлыг тусгаагүй. Тухайлбал, хуулиар олон нийтийн болон хувийн өмчлөлийг хүлээн зөвшөөрдөг ч хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бодлого, эрх зүй, зохицуулалтын аль ч түвшинд хүлээн зөвшөөрөөгүй байна.

2010 онд батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх” заалт анх удаа тусгагдсан юм.

УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигч болон орлогын тухай мэдээллийг ил болгоно; хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлнэ; хэвлэл нийтлэх эрх чөлөөг баталгаажуулна” хэмээн заажээ.

“Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын “Эзэмшлийн ил тод байдал” 4 дүгээр бүлэгт “Эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувь хэмжээ, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, дэлгэрэнгүй хаяг, харилцах утас, хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, удирдах ажилтнуудын иргэншлийн тухай мэдээллийг жил бүр Зохицуулах хороонд мэдээлж байх” үүргийг радио, телевизийн сувгуудад үүрэг болгосон юм. Мөн гадаадын аль нэг улсын телевизийн сувгийн тоо нь нийт гадаадын сувгийн 30 хувиас хэтрэхгүй (9.6) байхаар зохицуулжээ.

Эхний ээлжинд Улаанбаатар хотын телевиз, радио, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн (KaTV, АйПиТВ, Мобайл ТВ) эзэмшигчдийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулж, олон нийтэд зарласан байна.

Хэвлэл мэдээллийн эзэмшил, харьяаллын асуудал ил тод бус, борлуулалтын мэдээлэл болон хэрэглэгчдийн зах зээлд эзлэх хувийг нууцалдаг учир төвлөрлийг бодитоор тогтоох боломж хомс байна.

2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь хэсэгт хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авах тухай шинэ зохицуулалт хийсэн.

Олон төрлийн мэдээллийн хэрэгслийг янз бүрийн аргаар ил далд эзэмших бололцоо нээлттэй юм. Иймд аж ахуйн нэгжүүдээс эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа талаар өгч буй мэдээлэл нь эргэлзээтэй тул мэдээллийн хэрэгслийн жинхэнэ эздийг мэдэх боломжгүй байна.

Монголд хэвлэл мэдээллийн төвлөрлийн үйл явц гүнзгийрэх төлөвтэй байна. Бизнес, улс төрийн бүлэглэлүүд хэвлэл мэдээллийг төвлөрүүлэх, нэг нь нөгөөдөө худалдах үйл явц ид өрнөж байна.

“Өрсөлдөөний тухай” хуулийн зүйл заалт хэвлэл мэдээлэлд хамаарах боловч одоогоор тухайн хуулийг ашиглаж буй тохиолдол бараг байхгүй. Харин дээрх нөхцөл

шаардлагад 9.8-д “Тухайн зах зээлд давамгайлгагчаар тодорхойлогдсон тохиолдолд харилцаа холбооны салбарын өрсөлдөөний зохицуулалттай холбогдох журмыг дагаж, мөрдөхөөр заажээ.

“Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуульд төрийн өмчлөлийг хориглосон ч сүүлийн жилүүдэд он нутгийн засаг захиргааны мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олноор байгуулагдаж, хууль зөрчиж байна. Төрийн байгууллагаас эрхлэн ажиллуулж буй мэдээллийн хэрэгсэл бүгд тухайн байгууллагын бодлогыг сурталчлах зорилготой. Хэвлэл мэдээллийн өмчлөл нууц байх, хэвлэл мэдээлэл нэг гарт төвлөрөх нь редакцийн цензурыг өөгшүүлж, ингэснээр хэвлэлийн эрх чөлөөг боогдуулан, олон ургальч үзлийг сааруулж, сэтгүүл зүйн мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлдөг.

## **Бүртгэл**

Монгол Улсад бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүртгэлтэй байх ёстой бөгөөд байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор бүртгүүлэх өргөдлөө гаргах үүрэгтэй. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний хууль болон бусад хууль, журмыг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага нь хэвлэл мэдээллийн хэрэгслийг компани, эсвэл төрийн бус байгууллага гэсэн хоёр хэлбэрээр бүртгэж байсан. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 15.16.1 зүйлд заасны дагуу радио, телевизийн байгууллага нь зөвхөн тусгай зөвшөөрөл авсны дараа бүртгүүлэх ёстой. Харин тусгай зөвшөөрөл авахын тулд тухайн засаг захиргааны Засаг даргаас зөвшөөрөл авах шаардлагатай. Зөвшөөрөл авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд: тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, давтамж, бүтэц зохион байгуулалт, удирдлагын болон хариуцлагатай редакторын үүрэг хариуцлага, санхүүгийн мэдээлэл. Түүнчлэн хэвлэлийн компанитай байгуулсан гэрээг зайлшгүй хавсаргах шаардлагатай.

## **Зар сурталчилгаа**

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад аргаар нийтэд түгээж буй зар, сурталчилгааг “Зар сурталчилгааны тухай” хуулиар зохицуулдаг. Зар сурталчилгааны тухай ёс зүйн ямарваа нэгэн дүрэм байхгүй. Зар сурталчилгааны салбарт ёс зүйн хэм хэмжээ тогтоох нь зайлшгүй шаардлагатай боловч энэ талаар зар сурталчилгаа эрхлэгч болон түгээгчдийн дунд ямар нэгэн ойлголтгүй байна.

Төрийн байгууллагын зар, сурталчилгаа нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын хувьд орлогын чухал эх үүсвэр болдог. Гэвч энэ зардлын тухай мэдээлэл олон нийтэд ил тод биш байдаг. Сурталчилгааны зардлыг хэрхэн захиран зарцуулах тухай хуулийн заалт байдаггүй бөгөөд шийдвэрийг тухайн төрийн байгууллагын удирдлага гаргадаг. Төрийн мэдээлэл сурталчилгааны төсвийг хэрхэн хуваарилж байгааг хянах механизм байхгүй.

“Зар сурталчилгааны тухай” хуулийн 11 дүгээр зүйл болон “Олон нийтийн радио телевизийн тухай” хуулийн 13 дугаар зүйлд зар сурталчилгааг сэтгүүл зүйн бүтээлээс ялгаж зааглах тухай заасан. Гэвч, бодит амьдрал дээр эдгээр зүйл заалтууд хэрэгждэггүй бөгөөд тухайлбал, арилжааны телевизийн рейтинг өндөртэй нэг нэвтрүүлгийн дундуур 8-10 минутын рекламны блокийг 2-4 удаа цацаж буйг Хэвлэлийн Хүрээлэнгийн хэвлэл мэдээллийн хэрэглэгчийн судалгааны тайланд дурдсан байдаг.

Хэвлэл мэдээллийн зах зээл бүрэн төлөвшөөгүй, хэвлэл мэдээллийн байгууллагууд зар сурталчилгааны орлогын төлөө шударга өрсөлдөхөөсөө илүү улс төр, бизнесийн байгууллагатай гэрээ хийн, үйл ажиллагаа явуулж байна.

## Өргөн нэвтрүүлэг

Монголд өргөн нэвтрүүлгийн бие даасан хууль байдаггүй. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас “Өргөн нэвтрүүлгийн тухай” хуулийн төсөл боловсруулж, санал авч байна.

Олон улсын эрх зүйн жишгээр хэвлэл мэдээллийн салбарыг зохицуулах эрх мэдэл бүхий байгууллага нь Засгийн газраас хараат бус байж, давтамжийн зурвас хуваарилалтыг зохицуулах ёстой байдаг. “Харилцаа холбооны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн дагуу ХХЗХ-г 1995 онд байгуулсан ч үйл ажиллагааны хараат бус байдлыг тусгайлан баталгаажуулаагүй тул Засгийн газрын агентлагийн бүтцэд орж байна.

Харин “Радио долгионы тухай” хуулийн 4 дүгээр зүйлд “Радио долгион нь Монгол Улсын төрийн өмч бөгөөд радио давтамж, давтамжийн зурвас хуваарилах эрх дан ганц Засгийн газарт байна” гэжээ. Мөн хуулийн 5.2 зүйлд “ХХЗХ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллага мөн” гэж заасан нь хараат бус байгууллага биш гэдгийг илтгэнэ. Цаашилбал, “Радио долгионы тухай” хуулийн 10 дугаар зүйлд зааснаар, тусгай зөвшөөрөл авах хүсэлтэй байгууллагууд эхлээд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас тодорхойлолт авах ёстой. Энэ нөхцөл нь радио долгионы давтамжийн хуваарилалт хараат бус явагдах боломжийг хааж байна.

“Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэх ерөнхий нөхцөл, шаардлага”-ын дагуу кабелийн сувгаар өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт орсон юм. Урьд өмнө нь эдгээр телевиз зөвхөн кабелийн сувагтай байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаа эрхэлж байв.

Түүнчлэн уг журмын 9 дүгээр бүлэгт өргөн нэвтрүүлгийн байгууллагууд Өрсөлдөөний тухай хууль тогтоомж болон үл ялгаварлах, ил тод байх зарчмыг баримтлахаар тусгасан.

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийг “Олон нийтийн радио телевизийн тухай” хуулиар зохицуулж байна.

Тоон технологид шилжиж байгаатай холбоотойгоор өргөн нэвтрүүлгийн давтамж хуваарилалт, түүнтэй холбоотой тулгамдсан асуудал бодлогын түвшинд шийдлээ хүлээж байна.

## Интернэт

Монгол Улсад хэрэглэгчид дотоод, гадаадын аль ч сайтад нэвтэрч, нийгмийн сүлжээнд нэгдэж, харилцахыг төрөөс хязгаарласан зохицуулалт байхгүй. 2011 он хүртэл цахим сайт ажиллуулах, хувь хүн блог хөтлөх зэрэгт төрийн ямар нэгэн бүртгэл, зөвшөөрөл авах шаардлага тавигдаж байгаагүй. Харин 2010 онд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 15.16 дахь заалтад “контентын үйлчилгээ эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох” тухай нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу 2011 онд ХХЗХ-ноос “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага” гэсэн баримт бичгийг баталсан. Уг баримт бичигт “контент” гэдгийг “харилцаа, холбооны сүлжээгээр дамжиж байгаа тэмдэгт, дохио, текст, зураг, дуу, авиа, дүрс, бичлэг болон бүх төрлийн мэдээ мэдээллийг тоон хэлбэрт хувиргасан бүтээгдэхүүнийг хэлнэ” гэж тодорхойлжээ. Харин цахим шуудан, балк болон спам захидал, хувь хүмүүсийн хоорондын харилцаа (телефон яриа, факс, айпи телефон яриа гэх мэт) контентэд хамаарахгүй. Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай 01 тоот тогтоолыг баталсан. Энэ тогтоолын дагуу Зохицуулах хороо мэдээллийн сайтуудад тавигдах шаардлага, домэйн хаяг олгох ажлыг зохицуулах журам гаргах үүрэг хүлээв. Үндэсний Дата төвөөс сэтгэгдлийн нэгдсэн системийн техникийн ажиллагааг хангаж, Улсын бүртгэлийн ерөнхий газар сайтууд дээр сэтгэгдэл бичиж буй хэрэглэгчдийн



тухай мэдээллийг бүртгэж байх үүрэг хүлээсэн. Тэд хэрэглэгчдийн тухай мэдээлэл бүрдүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сан болон үүрэн телефон хэрэглэгчдийн мэдээллийг ашиглан гүйцэтгэх юм. Энэхүү цахим орчинд нэрээ нууцлах боломжийг хаасан тогтоол хүчин төгөлдөр хэвээр үйлчилж байна.

НҮБ-ын Үзэл бодлын эрх чөлөөний Тусгай илтгэгч, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын Хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч болон Америкийн муж улсуудын байгууллага (OAS)-ын Үзэл бодлын эрх чөлөөний Тусгай илтгэгч нарын 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталсан Хамтарсан Тунхаглалд “Интернэт үйлчилгээний нийлүүлэлт, цахим хуудас, блог буюу мэдээлэл түгээлтийн онлайн систем, түүнчлэн интернэт өргөн нэвтрүүлэг ажиллуулахын тулд бүртгүүлэх, төрийн аливаа байгууллагаас зөвшөөрөл авах ёсгүй. Энэ нь зөвхөн техникийн зориулалтаар домэйн нэрийн эрхийн бүртгэл, эсвэл арилжааны аливаа хэлбэрт хамааралтай ерөнхий хэрэглээний дүрэм журамд хамаарахгүй” хэмээн заасан байдаг.

Гэвч ХХЗХ нь хязгаарлалтыг дүрэм журмаар тогтоосоор байна. “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-д 2014 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр нэмэлт өөрчлөлтөөр “Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй мэдээ мэдээллийн вэб сайтын үйлчилгээ эрхлэгч нь Зохицуулах хороонд бүртгүүлнэ (3.5), лиценз авахаар болж байна. Бүртгэлийн гэрчилгээ авах хүсэлтэй бол өргөдөл, бүртгэлийн хураамж 80000 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 20000 төгрөг тус тус төлөх ёстой.

Энэ журмаар вэб сайтын үйлчилгээ эрхлэгчид нь хэрэглэгч контент үүсгэх боломжтой, хэрэглэгчийн сэтгэгдэл үлдээх хэсэгтэй бол дараах зохицуулалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ. Үүнд:

- Үгийн шүүлтүүр программ заавал ашиглах;
- Хэрэглэгчийн интернэт хаягийг (IP address) бүтнээр нь хэрэглэгчийн үүсгэсэн контентын дээр нийтэд харагдахуйц байрлуулах;
- Хэрэглэгч дурын нэр (username), имэйл хаягаар логин хийх сэтгэгдэл үлдээх боломжийг бүрдүүлэх
- Тухайн сэтгэгдэлтэй холбоотой үүсэх логийг багадаа 6 сар хадгална.

Энэ ерөнхий нөхцөл шаардлагыг биелүүлээгүй вэбсайтын үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлана.

Зохицуулах хороо нь холбогдох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хууль, тогтоомж зөрчсөн тухай албан ёсны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн 24 цагийн дотор зөрчил арилгах үүрэг өгөх, шаардлагатай гэж үзвэл мэдэгдэл хүргүүлэхгүйгээр вэб сайтын хандалтыг нэн даруй хязгаарлаж болохоор заажээ. Зохицуулах хороо зөрчлөөс хамааруулан эдийн засгийн хариуцлага хүлээлгэх эсвэл хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх; захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх; тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах; хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах эрхтэй байхаар журамласан байна.

## **Сэтгүүлчийн нууц эх сурвалж**

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоо бий болгох талаар сүүлийн жилүүдэд өргөн хэлэлцүүлэг өрнүүлж, энэ чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэргэжлийн эвлэл холбоод идэвхтэй хамтран ажилласны үр дүнд 2015 оны нэгдүгээр сарын 28-ны өдөр Хэвлэл мэдээллийн зөвлөлийг байгуулав. Тус зөвлөл нь Удирдах зөвлөл (15 хүн), телевиз, радиогийн ёс зүйн хороо (15 хүн), сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хороо (15 хүн), ажлын алба, гүйцэтгэх захиралтайгаар үйл ажиллагаа явуулахаар



шийдвэрлэж, 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн гомдол хүлээн авч шийдвэрлэхэд бэлэн болов.


Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим” -ыг баталсан.

# ХОЁР. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЗӨРЧИЛ 2012-2014 ОНД

Глоб Интернэшнл Төв нь 2005 оны 10 дугаар сараас эхлэн сэтгүүлчдийн мэргэжлийн эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчилд мониторинг хийж байна. 2015 оны нэгдүгээр сар хүртэлх мониторингийн дүнгээр нийт 375 эрхийн зөрчил бүртгэв.

Зөрчлийн хэлбэр	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	Нийт
Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан	3	3	6	-	-	1	5	-	4	22
Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан	16	7	23	13	10	8	5	6	9	97
Мэдээлэл өгөхөөс татгалзсан /мэдээлэл олж авах, түгээхэд саад хийсэн	8	10	13	2	-	7	7	8	11	66
Ажлын багаж хэрэгсэлд халдсан	3	3	2	-	2	2	4	2	2	20
Шүүх, хүчний байгууллагын дарамт /шүүхэд нэхэмжлэл гаргасан	2	8	5	3	5	3	5	6	8	45
Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан	3	1	5	1	6	3	4	11	9	43
Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх хэлбэрийн цензур	2	1	3	1	2	3	9	9	4	34
Эрүүгийн хэрэг үүсгэсэн, түр саатуулагдсан, хоригдсон	4	4	2	0	5	6	6	10(1)	8(2)	48
<b>Нийт</b>	<b>41</b>	<b>37</b>	<b>59</b>	<b>20</b>	<b>30</b>	<b>33</b>	<b>45</b>	<b>53</b>	<b>57</b>	<b>375</b>

### Сэтгүүлчдийн мэргэжлийн эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн тоо (оноор)



2012 онд 22 сэтгүүлч, ХМХ-тэй холбоотой мэргэжлийн эрхийн 45 зөрчил гарсан бол 2013-2014 онд нийт 57 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага, ТББ, хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчлийн 110 тохиолдол бүртгэгджээ.

2012 онд эрх нь зөрчигдсөн сэтгүүлч, ХМХ-ийн 12 буюу 54,5 % өдөр тутмын сонин, 7 буюу 23% нь телевиз, 3 буюу 13,6% нь цахим хуудасных байна. Орон нутгаас хандсан 7 тохиолдол байна. Энэ нь нийт зөрчлийн 32% болж байна.

2013-2014 онд гарсан зөрчлийн 18 буюу 31,6% нь сонин, сэтгүүл, 16 буюу 28,1% нь телевиз, 19 буюу 33,3% нь вэб сайт, хувь хүн, ТББ – 4 буюу 7% байв. Эдгээр зөрчлийн ихэнх нь буюу 79% нь Улаанбаатар хотод, 21% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Орон нутгаас бидэнд хандах сэтгүүлчдийн тоо урд жилүүдтэй харьцуулахад буурах хандлагатай байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрх зөрчигчдийн 61,4% нь төрийн байгууллага, улс төрчид, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчид байна.

2013-2014 онд гарсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийг ангилбал:

- Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан - 4 (3,6%)
- Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан- 15 (13,6%)
- Мэдээлэл өгөхөөс татгалзсан /мэдээлэл олж авах, түгээхэд саад хийсэн – 19 (17,3%)
- Ажлын багаж хэрэгсэлд халдсан – 4 (3,6%)
- Шүүх, хүчний байгууллагын дарамт /шүүхэд нэхэмжлэл гаргасан – 14 (12,7%)
- Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан - 20 (18,3%)
- Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх хэлбэрийн цензур – 13 (11,8%)
- Эрүүгийн хэрэг үүсгэсэн, түр саатуулагдсан, хоригдсон - 21 (19,1%)

**Глоб Интернэшнл Төв 2012–2014 онд гарсан сэтгүүлчдийн мэргэжлийн эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрхэнд халдсан дараах зөрчлийг онцолж байна.**

- Сэтгүүлч Л.Баяраа “Улс төрийн тойм” сонины 2012 оны 5 дугаар сарын 21-ний дугаарт “УИХ-ын гишүүн Д.Одхүүгийн сонгуулийн нууц төлөвлөгөө алдагдав” гарчиг бүхий нийтлэл хэвлүүлжээ. Уг нийтлэлээс үүдэн Д.Одхүү нэр төрд халдсан, үндэслэлгүй мэдээлэл нийтэлсэн хэмээн гомдол гаргасны дагуу сэтгүүлчид эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдөр хэргийг шүүхэд шилжүүлэх үеэр сэтгүүлчийг хавтаст хэрэгтэй нь танилцуулалгүй, шүүгчийн захирамжгүйгээр 3 цаг хорьж саатуулжээ. Сэтгүүлч Л.Баярааг шүүх хуралд 20 гаруй минут хоцорч очиход Баянгол дүүргийн шүүгчийн захирамжаар сэтгүүлчийг дахин баривчлан хорьжээ. 2012 оны 7 дугаар сарын 26-нд болсон шүүх хурлаар сэтгүүлч Л.Баярааг гэм буруутай гэж үзэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 70 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу 9.828.000 төгрөгний торгууль ноогдуулсан байна.
- 2012 оны 6 дугаар сарын 28-наас 29-нд шилжих шөнө 01 цагийн үед буюу УИХ-ын сонгуулийн санал хураалт явагдсаны дараа “Скай” телевизийн хөрөнгө оруулагч болох “Хөвсгөл Ньюс” компаний гүйцэтгэх захирал Б.Ганзориг хэсэг хүмүүсийн хамтаар тус телевизийн 4 сэтгүүлч, 4 зураглаачдыг нэг талыг барьсан мэдээлэл явуулсан, хөрөнгө оруулагчдынхаа талд үйлчилсэнгүй хэмээн зодож гэмтээсэн байна. Б.Ганзориг нь УИХ-ын сонгуулийн 17 дугаар тойрог буюу Хөвсгөл аймагт нэр дэвшигч Л.Мөнхбаатарын сонгуулийн сурталчилгааны ажлыг гардан гүйцэтгэгч нь бөгөөд сонгуулийн дүн гарсны дараа ийнхүү телевизийн зураглаач, сэтгүүлчдээ зодож танхайрсан болох нь дүрс бичлэгт үлджээ. Халдлагад өртсөн нэг сэтгүүлч, хоёр зураглаач тархиндаа хүнд гэмтэл авчээ. Шүүхээс Б.Ганзоригт 3.5 жилийн хорих ял ногдуулсан байна.
- Сэтгүүлч Ц.Эрдэнэцэцэг “Өдрийн шуудан” сонины 2012 оны 11 дүгээр сарын дугаарт “Дугаарын бизнес дундраагүйгээр барахгүй илүү нарийн, илүү цадиггүй болон хөгжиж байна” гарчигтай нийтлэл гаргажээ. Нийтлэлийн улмаас Зам, тээврийн яамны Хяналт бүртгэлийн газрын дарга Б.Жаргалын гомдлоор 2013 оны 1 дүгээр сард сэтгүүлчид эрүүгийн хэрэг үүсгэжээ. 2013 оны 6 дугаар сард болсон анхан шатны шүүх хурлаар сэтгүүлчийг цагаатгасан боловч давж заалдах шатны шүүх хурлаар хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах шийдвэр гаргасан байна. 2014 оны 6 дугаар сард Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхээс сэтгүүлчийг бусдыг санаатай гүтгэн, гүтгэлгийг олон нийтэд тараасан гэм буруутай гэж үзэн, 7.160.400 төгрөгийн торгох ял ногдуулсан бөгөөд давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхээс оноосон ялыг хэвээр үлдээх шийдвэр гаргажээ. Харин 2014 оны 10 дугаар сард Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар сэтгүүлчийг цагаатгасан юм.
- 2014 оны 8 дугаар сарын 18-нд Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхээс Ц.Батыг Зам тээврийн сайд А.Гансүхийн нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүтгэлгийг олон нийтэд тараасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн 111.2 дугаар зүйлийн дагуу гурван сар 10 хоногийн хугацаагаар баривчлах ялаар шийтгэжээ. Жиргээч Бат инженерийн “хэрэг”-ийг найман сарын хугацаанд шалгасан гэх бөгөөд түүнийг гурван сарын хугацаанд 5000 гаруй удаа А.Гансүхийн нэр төрд халдаж жиргэсэн хэмээн шүүх үзжээ. ЕАБХАБ-ын хэвлэлийн эрх чөлөөний

төлөөлөгч Дуня Миятович Ц.Батад ял ноогдуулсантай холбогдуулан мэдэгдэл гаргасан байна<sup>5</sup>. 2014 оны 9 дүгээр сарын 9-нд Ц.Батад холбогдох хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж, түүнийг батлан даалтад гаргах шийдвэр гаргахыг шийдвэрлэжээ. Жиргээч Ц.Бат 22 хоног хоригдсон байна.

- Увс аймгийн сэтгүүлч С.Анхбаярт Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд болон бусад 10 тэргүүлэгч нэр төрд халдаж, гүтгэн доромжилсон мэдээ мэдээллийг цахим ертөнцөөр тараасан гэдэг үндэслэлээр 2014 оны 12 дугаар сард Эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. С.Анхбаяр аймгийн удирдлагуудын үйл ажиллагааг шүүмжилж байсан бөгөөд “Ундарга Увс” компанид хоёр ШТС-ын газрыг Газрын тухай хууль зөрчиж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр баталж олгосон тухай, аймгийн 19 сумын ИТХ-ын ажлын албанд шахмал модон алхыг тус бүрийг 300 мянган төгрөгөөр өгсөн тухай, аймгийн ИТХ-ын сүүлчийн хуралдааны үеэр төлөөлөгчдийг нэг орой 3 сая төгрөгөөр дайлсан тухай мэдээллүүдээс үүдэн хэрэг үүсгэжээ.
- 2012 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр “ТВ 8” телевизийн сэтгүүлчид сурвалжилга хийх явцдаа бусдад зодуулсан хэрэг гарчээ. “ТВ 8” телевизэд “Blue Sky” цамхагт ажилладаг нэг залуу ажлын байрандаа солонгос хүнд зодуулж байна гэсэн дуудлага ирсний дагуу сурвалжлах баг тус газар очжээ. Гэтэл хамгаалалтын албаны хүмүүс камертай сэтгүүлчдийг орохыг хориглож, харин гар хоосон сэтгүүлчдийг ажлын байр руу нэвтрүүлжээ. “ТВ 8” телевизийн сэтгүүлч гар утсаараа бичлэг хийж байтал солонгос, монгол хүмүүс нийлж гар утсыг нь булаан авч бүлэглэн зоджээ. Зодуулсан сэтгүүлчийн үс нь зулгарч гэмтсэн бөгөөд гар утсаа алдсан байна.
- “SBN” телевизийн сурвалжлах багийн сэтгүүлч, зураглаачид 2012 оны 9 дүгээр сарын 28-наас 29-ний шилжих шөнө Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэстэй хамтран тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг баар цэнгээний газрууд хууль зөрчин, цаг хэтрүүлэн ажиллаж байгаа талаар сурвалжилжээ. Гэтэл “ХО” баарны эзэн “Бидний ард том хүн байгаа. Та нар яаж ч чадахгүй” гэх зэргээр доромжилж, цагдаа нарын хууль ёсны шаардлагыг эсэргүүцэж, хамгаалалтын ажилтнуудаар сэтгүүлч, цагдаа нарыг зодуулжээ. Тэрээр “SBN” телевизийн сурвалжлагч, зураглаач нарыг шалгалтаар очсон хоёр цагдаагийн хамт баарандаа цоожилж, тухайн үед хийсэн бичлэгийг нь хүчээр устгахыг оролдсон байна. Мөн тус телевизийн зураглаачийг зодож, тархинд нь хүнд гэмтэл учруулсан бөгөөд SBN телевизийн камерийг дахин ашиглагдахааргүй болтол эвдэлжээ.
- “Зууны мэдээ” сонины сэтгүүлч Д.Болормаад “Мон Уран” компанийн захирал Б.Наранхүүгийн гомдлоор Сүхбаатар дүүргийн шүүхэд Эрүүгийн хэрэг үүсгэн, анхан шатны шүүхээс 2011 оны 8 дугаар сард хэрэгсэхгүй болгож, гомдол гаргачийн зүгээс давж заалдсан учир 2012 оны 2 дугаар сард тус дүүргийн шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад буцаажээ. 2012 оны 9 дүгээр сард шүүхээс сэтгүүлчийн гэм бурууг тогтоож, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 61 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 8.5 сая гаруй төгрөгний мөнгөн торгууль ногдуулжээ. Нийслэлийн Дээд шүүхээс 2013 оны 5 дугаар сард сэтгүүлчид ногдуулсан ялыг хэвээр баталсан байна. Энэ хэрэг Б.Наранхүүг УИХ-ын гишүүнээр сонгогдсоны дараа эрчимтэй өрнөж, сэтгүүлчийг шат шатны шүүхээс буруутгасан тогтоол гаргасан нь сонирхол татаж байна.
- “Өглөөний сонин”-ы сэтгүүлч Р.Саруултөгс 2013 оны тавдугаар сард Герман Улсад суух элчин сайд Б.Даваадоржийн данс руу Монгол Улсаас таван

<sup>5</sup> <http://www.osce.org/fom/122969>

удаагийн үйлдлээр 2100 евро орсон гэдэг мэдээлэл, мөн өмнө нь энэ хүний холбогдож байсан хэргийн хурлын протоколуудыг олон нийтэд хүргэжээ. Сэтгүүлчийг бусдыг гүтгэсэн, нэр хүндийг нь гутаан доромжилсон гэдэг үндэслэлээр Эрүүгийн хуулийн 111.2 зүйлээр жил гаруй хугацаанд шалгажээ. Прокурор хэргийг 3 удаа хэрэгсэхгүй болгосон боловч тухай бүрт Ерөнхий Прокурор хэргийг сэргээн, өөр хүнд шилжүүлдэг байв. Хэргийг УМБГ-ын мөрдөн байцаах тасгийн онц ноцтой хүнд гэмт хэрэгтэй тэмцэх тасаг шалгасан нь сонирхол татаж байна. 2014 оны 7 дугаар сарын 29-нд болсон Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүх хуралдаанаар сэтгүүлч Саруултөгсд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгах тогтоол гаргажээ.

- News.mn вэбсайт 2014 оны 8 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд “Хурандаа нарын ард хэн байв”, “АТГ-ын дээр “хөх тэнгэр” л бий” гарчигтай нийтлэлүүд гаргасны дараа буюу 6-ны үдээс хойшоос эхлэн вэбсайтын үйл ажиллагаа доголдож эхэлжээ. Редакцийн зүгээс үүнийг хянах боломжгүй болсон бөгөөд мэдээ нийтлэлийн гарчигууд өөрчлөгдөн, доромжилсон үг хэллэгээр солигдсон байна. Иймээс сайтын үйл ажиллагааг түр хаахаас аргагүй байдалд хүрчээ. Редакцийн хувьд контент үйлдвэрлэдэг, харин сайтын программ хангамжийг өөр компани гэрээгээр хариуцдаг байв. Орой сайт нээгдэхэд дээр дурдсан 2 нийтлэл устгагдсан байсан ба нийт 5 материалын гарчигийг доромжилсон үг хэллэгээр сольсон нь санаатай үйлдэл гэдэг дүгнэлтэнд хүргэж байна. Сайтын зүгээс ТЕГ-ын Кибер аюулгүй байдлын газарт албан ёсоор хандсан боловч хоёр сарын дараа хэргийг үйлдсэн этгээдийг тогтоох боломжгүй гэсэн хариу авчээ.
- 2014 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Amjilt.com вэб сайтын сэтгүүлч гэрэл зураг бүхий баримтан дээр тулгуурлан “Ерөнхий сайдын “Хаан жимс” амралтын газар Туул гол руу бохироо асгаж байна” гарчигтай нийтлэл бичжээ. Тус нийтлэл гарсны маргааш буюу 7 дугаар сарын 4-ний өдөр ХХЗХ-ны холбогдох албан тушаалтан тус сайтын удирдлага руу утасдаж “Хаан жимс” амралтын газрын гомдлын дагуу ярьж байна” гээд нийтлэлээ устгахыг шаардаж “Гүтгэлгийн мэдээ байна. Залруулга гарга. Тэгэхгүй бол танай сайтыг цагийн дараа хаана” хэмээн сүрдүүлжээ. Энэ ярианаас хойш 3 цагийн дараа тус сайтыг ХХЗХ-ны хар жагсаалтад бүртгэн, хаажээ. ЕАБХАБ-ын хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч Дуня Миятович Amjilt.com мэдээллийн вэбсайтыг үндэслэлгүйгээр хаасан үйлдэлтэй холбогдуулан мэдэгдэл гаргасан байна<sup>6</sup>.
- Зам, тээврийн сайд асан А.Гансүх твиттер хуудаснаа “МИАТ-д хийсэн шинэчлэлээр 3.6 тэрбум төгрөг хэмнэсэн” хэмээн бичжээ. Үүний хариуд иргэн Л.Даваапил “Самсунг корпорацитай нэг километр төмөр замыг хэдээр гэрээлсэн бэ? Тэнд луйвардсан мөнгө чинь наад 3.6 тэрбумаас чинь хол байна” хэмээн бичсэнээс үүдэн А.Гансүх Л.Даваапилийн эсрэг Эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр гомдол гаргасан байна. 2015 оны 1 дүгээр сард шүүх хэргийг хэлэлцээд Л.Даваапилийг хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэгийг олон нийтэд тараасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 9.7 сая төгрөгний торгууль ногдуулсан байна. Харин 2015 оны 2 дугаар сарын 17-нд болсон шүүх хуралдаанаар Л.Даваапилд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

<sup>6</sup> <http://www.osce.org/fom/121076>

# ГУРАВ. СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭСРЭГ ИРГЭНИЙ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

Глоб Интернэшнл Төв нь улсын хэмжээнд 2012, 2013 болон 2014 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан иргэний хэрэг, маргаан, бусдыг гүтгэсэн, доромжилсон эрүүгийн хэргүүдийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн байдлыг судлан, Иргэний болон Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага хэрхэн ашиглаж буйд судалгаа хийсэн юм.

Монгол Улсын Иргэний хуулийн 21, 27, 497, 511 дүгээр зүйлүүдэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, учирсан гэм хорын хохирлыг арилгах, Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлд доромжлох, 111 дүгээр зүйлд гүтгэх үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцохоор тус тус зохицуулсан байдаг. Судалгааг shuukh.mn цахим хуудасны мэдээлэлд үндэслэв.

Монгол Улсын хэмжээнд 2012 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбогдох иргэний 43 хэрэг, 2013 онд 37 хэрэг, 2014 онд 45 хэрэг шийдвэрлэгдсэн байна.

Эдгээрээс 2012 онд шийдвэрлэгдсэн 20 иргэний хэрэг, 2013 онд иргэний 17 хэрэг, 2014 онд иргэний 20 хэрэгт сэтгүүлч, иргэний сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан хэмээн хариуцагчаар татагдсан байна.

2012 онд гүтгэлэг доромжлолтой холбоотой эрүүгийн 8 хэргийн 4 нь, 2013 онд 9 хэргийн 3 нь, харин 2014 онд 12 эрүүгийн хэргийн 9 нь сэтгүүлч, иргэний сэтгүүлч, ХМХ-тэй холбоотой байна.

2012-2013 онд нэхэмжлэгчдийн 56% нь улс төрч, төрийн өндөр албан тушаалтан, төсвийн байгууллага, төрийн байгууллага, 34% нь хувийн байгууллага, компани, 10% нь иргэд байв. 2014 онд нийт нэхэмжлэл гаргагчдын 30% нь төрийн байгууллага болон төрийн өндөр албан тушаалтнууд, 35% нь хувийн компани, 20% нь олон нийтийн байгууллага, иргэд, харин 15%-д нэхэмжлэгч тодорхойгүй байна.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээлгэхээр 2012 онд нэхэмжилсэн мөнгөн дүнгийн дээд хэмжээ 200 сая төгрөг байсан бол 2013 онд төрийн өндөр албан тушаалтан 500 сая төгрөг нэхэмжилсэн байна. 2014 онд нэхэмжилсэн мөнгөн шаардлагын дээд хэмжээ мөн 500 сая төгрөгт хүрч, үүнээс хариуцагч төлөхөөр болсон мөнгөн дүнгийн хамгийн их хэмжээ 45 сая төгрөг байна.

2012 онд шүүхээр шийдвэрлэгдсэн 7 иргэний хэрэг, 2013 онд - 8, 2014 онд мөн 8 иргэний хэрэгт хариуцагч буруутай гэсэн шийдвэр гаргажээ.

2012-2013 онд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох 20 хэргээс 13 хэрэгт хариуцагч хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлч өмгөөлөгчгүй оролцжээ.

Нэхэмжлэгч компаниуд нэхэмжилсэн мөнгөн дүндээ зар сурталчилгаа явуулахаар харилцан тохиролцож, эвлэрлийн гэрээ хийсэн байна.

2012 онд шийдвэрлэсэн эрүүгийн хэрэгт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 70 дахин нэмэгдүүлсэн буюу 9.828.000 төгрөгөөр торгох ял ноогдуулсан нь мөнгөн торгуулийн дээд хэмжээ байсан бол, 2013 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэн буюу 14.040.000 төгрөгийн торгох ял ногдуулжээ. Харин 2014 онд шийдвэрлэсэн эрүүгийн хэрэгт 111.2 зүйлийн дагуу 3 сар 10 хоног баривчлах ялаар шийтгэх, мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу 9.792.000 төгрөгөөр торгох ял ногдуулах зэргээр шийдвэрлэсэн байна.

1999-2014 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, гүтгэлэг, доромжлолтой холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн 687 хэргийн 386 буюу 56.2 хувь нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох хэрэг байна.

### 1999–2014 оны хэргийн харьцуулсан үзүүлэлт

Он	Иргэний хэрэг		Эрүүгийн хэрэг	
	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах
1999	30	-	3	-
2000	39	-	-	-
2001	31	11	4	-
2002	44	37	2	2
2003	28	18	1	1
2004	40	40	1	1
2005	29	25	1	1
2006	36	31	3	3
2007	33	33	-	-
2008	39	25	5	5
2009	44	17	1	-
2010	67	37	2	-
2011	43	23	7	3
2012	43	20	8	4
2013	37	17	9	3
2014	45	20	12	9
<b>Бүгд</b>	<b>628</b>	<b>354</b>	<b>59</b>	<b>32</b>



\*\*\* \*\*

Сэтгүүлчид өөрсдөд тохиолдож буй мэргэжлийн эрхийн зөрчлийг олон нийтэд мэдээлэхийг хүсдэггүй, цаашдын дарамт шахалтаас болгоомжлон, айдас хүйдэст автах нь түгээмэл байна. Энэ байдлаас үүдэн, сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн бодит тоо, баримтыг гаргах боломжгүй, ихэнх зөрчил далд болж өнгөрдөг, сэтгүүлчид ч энэ байдлыг хэвийн зүйл мэт хүлээж авах болсон нь харамсалтай.

Мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад учирч байгаа аливаа дарамт, бэрхшээлийг илчлэх нь өөрийнхөө болон мэргэжил нэгтнүүдийнхээ эрхийг хамгаалахад чухал хувь нэмэр болох төдийгүй нийтлэг үйлс, нийтлэг зорилгынхоо төлөө дуу хоолойгоо нэгтгэн эрх баригчдад хүргэх боломж билээ.

Эцэст нь, хэвлэлийн эрх чөлөө бол энэ тайланг уншиж буй Монгол Улсын иргэн таны эрх чөлөө билээ. Хэвлэл мэдээлэл аль хэр хараат бус байна төдий чинээ таны үнэн мэдээлэлтэй байх эрх хангагдана. Иймд хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулахад таны ч хувь нэмэр чухал билээ.

# ХАВСРАЛТ-1

2013 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр УИХ, Засгийн газарт хандаж гаргасан

## УРИАЛГА

Энэ жил дэлхий нийтээрээ 20 дахь удаагаа Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тэмдэглэж байна. ЮНЕСКО, Олон улсын сэтгүүлчдийн холбооны хамтарсан Уэндхүегийн тунхаглал 1991 оны 5-р сарын 3-нд батлагдаж, 1993 оноос Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тэмдэглэж эхэлсэн билээ. Энэ жил НҮБ-ээс Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг “Үгээ хэлэхээс үл эмээх нь: хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах нь” сэдвийн дор “Сэтгүүлч, ХМХ-ийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах нь”, “Хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг ял шийтгэлгүй үлдээхтэй тэмцэх нь”, “Цахим орчны аюулгүй байдал” хэмээх гурван дэд сэдвийн хүрээнд тэмдэглэж байна.

“Хараат бус хэвлэл мэдээлэл гэж засгийн газар, улс төр, эдийн засгийн хувьд, мөн үйлдвэрлэл, түгээлттэй холбоотой материал, дэд бүтцээс хараат бус байхыг хэлнэ” хэмээн Уэндхүегийн тунхаглалд тодорхойлсон байдаг. Монгол Улс чөлөөт, хараат бус хэвлэлийг хөгжүүлэх, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах чиглэлээр тодорхой амжилтад хүрсэнийг сайшааж байна.

Ялангуяа, ирэх долоо хоногоос олон нийтээр хэлэлцүүлэх гэж буй Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар нэр төр гутаахтай холбоотой зүйл заалтыг халсаныг бид олон улсын хамтын нийгэмлэг, НҮБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж буй шударга, дэвшилттэй үйл хэрэг хэмээн талархан сайшааж байна. 2012 оны УИХ-ын сонгуулийн үеэр “Глоб Интернэшнл төв” ТББ-аас явуулсан “АСУУЯ!” кампанит ажлын үеэр “нэр төр гутаасан гэх хэргийг Эрүүгийн хуулиар бус, Иргэний хуулиар шийдвэрлэдэг” байхыг дэмжсэн МАН, Иргэний зориг, Ногоон нам, “Шударга ёс” эвсэл, АН-ын гишүүд амлалтаа биелүүлж, намрын чуулганаар Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх явцад энэ дэвшилтэт зүйл заалтыг эргэн нэхэхгүйгээр батална гэдэгт итгэж байна.

“Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний энэ өдөр бид Засгийн газрууд, нийгэм, хувь хүмүүсийг цахим болон цахим бус орчинд ажиллаж буй бүх сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд бололцоотой бүхнээ хийхийг уриалж байна. Хүн бүр дуу хоолойтой. Бүгдээрээ чөлөөтэй, аюулгүй байдалд ярих, хэлэх боломжтой байх ёстой” хэмээн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн, ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал Ирина Бокова нар Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулсан Хамтарсан илгээлтдээ дурдсан юм. Тэд мөн Хамтарсан илгээлтдээ “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд өдөр бүр шинэ түгшүүр тулгарч байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь олон нийттэй холбоотой асуудалд ил тод, хариуцлагатай байдлыг хангахад тусладаг учраас сэтгүүлчид байнга хүчирхийллийн бай болдог” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Монгол иргэн бүрийн үзэл бодлоо илэрхийлэх, айдас хүйдэсгүйгээр үгээ хэлэх эрх өнөөдөр төдийлөн баталгаатай бус, ялангуяа цахим орчинд өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах хандлага хүчтэй байгааг бид эрс буруушааж байна. Иймд УИХ, шинэчлэлийн Засгийн газрын гишүүдэд уриалж байна. Үүнд:

1. Иргэдийн шүүмжлэх эрх, нэрээ нууцлах эрхийг хязгаарлаж, интернэтийн цензур тогтоож байгаа учраас Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 1-р сарын 5-ны өдрийн “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн системийн тухай” **НЭГ** тоот тогтоолыг цуцлах
2. 2011 онд батлагдсан “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”, “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”, ялангуяа бүртгэл, шүүлтүүртэй холбоотой заалтыг НҮБ, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөх
3. Төрийн цензур бий болгох нөхцөл бүрдүүлж байгаа учраас Харилцаа холбооны зохицуулах хорооны хараат бус байдлыг бүрэн утгаар нь хангах. Үүний тулд “Харилцаа холбооны тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах, удирдлагыг нь Ерөнхий сайд томилдог 8.3 зүйл заалтыг өөрчлөх. Тусгай зөвшөөрөл олгох, агуулгад хяналт тавих, түүнтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцыг олон нийтийн оролцоотой, ил тод болгох
4. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 19-р зүйлийн дагуу хэвлэл мэдээллийн агуулгын хязгаарлалтыг гагцхүү хуулиар, үндэслэлтэй, хэр хэмжээндээ, нарийвчлан тогтоохын тулд агуулгад тавьсан бүх хязгаарлалтыг эргэн нягтлах, шаардлагатай өөрчлөлт хийх
5. Сэтгүүлчийн мэдээллийн нууц эх сурвалжийг хамгаалах, мөн үзэл бодлоо илэрхийлэхдээ иргэн хүн нэрээ нууцлах нь түүний хувийн нууцын салшгүй хэсэг болохыг хүлээн зөвшөөрч, хуульчлах
6. Хэвлэл мэдээллийн олон талт байдал, олон ургальч үзлийг хөхиүлэн дэмжихийн тулд хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл /community media/-ийн бодлого, эрх зүй, зохицуулалтын орчинг бүрдүүлэх

НҮБ-ын Хүний эрхийн хороо 2011 оны гуравдугаар сарын 21, 23-ны өдрүүдэд Монгол Улсын 1974 онд соёрхон баталсан, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пакт /ИБҮТЭОУП/-ын хэрэгжилтийн тухай Засгийн газрын тавдугаар тайланг 2784, 2785 дугаар уулзалтаараа хэлэлцсэн билээ. 2011 оны гуравдугаар сарын 30-ны өдөр болсон 2797 дугаар уулзалтаараа НҮБ-ын Хүний эрхийн хороо Монгол Улсад өгсөн дүгнэлт зөвлөмждөө “Сэтгүүлч, түүний гэр бүлийнхэнд, сүрдүүлж заналхийлэх, халдах тохиолдол байнга гардаг...”-т санаа түгшиж байна гээд “Сүрдүүлэг заналхийлэл, халдлагын аливаа тохиолдлыг хуулийн дагуу мөрдөн шалгаж, гэмтэнд хариуцлага хүлээлгэхэд Оролцогч улс анхаарах”-ыг зөвлөсөн юм.

Энэ зөвлөмжийн хэрэгжилтийн тухай тайлангаа Монголын Засгийн газар 2015 онд НҮБ-ын Хүний эрхийн хороонд тавьж хэлэлцүүлнэ. Энэ тухай Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр бид эргэн сануулж байна. Учир нь, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээд ял шийтгэлгүй үлдэх нь Монгол Улсад бараг хэвийн зүйл болоод байгаа билээ.

**“Глоб Интернэшнл төв” төрийн бус байгууллага,**

**Монголын сэтгүүлчдийн эвлэл**

**Монголын өдөр тутмын сонинуудын холбоо**

**Монголын сонины холбоо**

**Монголын телевизүүдийн холбоо**

**Монголын сайтын холбоо**

**Монголын хэвлэлийн хүрээлэн**

2013 оны тавдугаар сарын 1-ний өдөр

# ХАВСРАЛТ-2

Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форумын гишүүн Глоб Интернэшнл Төв 2014.09.15-нд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг /UPR/-ийн хоёр дахь мөчлөгт “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө” сэдэвт мэдээлэл бэлтгэж, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлэв.

## ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Энэхүү илтгэлийг Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форумын гишүүн “Глоб Интернэшнл Төв”<sup>7</sup> төрийн бус байгууллага бэлтгэв. Илтгэлийн эхний танилцуулгыг 2014 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн иргэний нийгмийн байгууллагуудын чуулганаар танилцуулж, хэлэлцүүлэв. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн эхний зөвлөмжид манай тайлангийн сэдэв тусгагдаагүй ч, 2010 онд илтгэл явуулснаас хойш Монгол Улсад бий болсон улс төр, эрх зүй, зохицуулалтын нөхцөл байдлаас иргэдийн үзэл бодолтой байх эрх, илэрхийлэх эрх чөлөөний асуудал түгшүүр дагуулах болж, ялангуяа Засгийн газраас цахим эрх чөлөөг хязгаарлах алхмууд хийгдэж эхэлсэн, Эрүүгийн хуулийн нэр төр гутаахтай холбоотой зүйл заалтыг нийтийн албан тушаалтнууд ашиглах нь нэмэгдэж буй нь энэ илтгэлийг бичих үндэслэл болов.

### А. Олон улсад хүлээсэн үүрэг

НҮБ-ын гишүүн орны хувьд Монгол Улс Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрч, 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИБУТЭТОУП)-ыг соёрхон баталсан. Хууль хэрэглээний талаасаа авч үзвэл, Үндсэн хуулинд зааснаар хүний эрхийг баталгаажуулсан олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг үндэсний хуулиудтай харшилдах нөхцөл үүссэн тохиолдолд олон улсын хэм хэмжээ нь дотоодын хуулиас давуу эрэмбэтэй үйлчилнэ. 2005 онд анх хэвлэгдсэн “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаарт Пактын албан ёсны орчуулгыг нийтэлснээр шүүхэд хэрэглэх эрх зүйн орчин бүрэн бүрдсэн болно.

2011 оны 3 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн хороо 101 дэх хуралдаанаараа Монгол Улсын Засгийн газрын ИБУТЭОУП-ын хэрэгжилтийн тухай ээлжит тайланг хэлэлцээд, Монгол Улсын Засгийн газарт “Нэр төр гутаахыг эрүүгийн гэмт хэргээс хасч, сэтгүүлчийг аливаа сүрдүүлэг заналхийлэл, халдлагаас хамгаалах шаардлагатай арга хэмжээ авах, сүрдүүлэг заналхийлэл, халдлагын аливаа тохиолдлыг хуулийн дагуу мөрдөн шалгаж, гэмтэнд хариуцлага хүлээлгэхэд” анхаарал хандуулах зөвлөмж өгсөн билээ.

Пактын 19-р зүйл<sup>8</sup>, Монгол Улсын Үндсэн хуулийн 16.17 дугаар зүйлд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тавих хязгаарлалтыг зөвхөн хуулиар тогтоох ёстой ч Монгол Улсад бодит байдал өөр байна.

### Б. Үндсэн хууль болон бусад хууль

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулийнхаа 16.16, 16.17 зүйлээр иргэдийнхээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэлтэй байх эрхийг баталгаажуулсан

<sup>7</sup> 1999 оноос хойш үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж буй энэ байгууллага IFEX, Forum Asia, GFMD олон улсын байгууллагын гишүүн юм

<sup>8</sup> ИБУТЭОУП-ын 19-р зүйл (З)

юм. Мөн “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хууль (1998), “Олон нийтийн радио, телевизийн тухай” хууль (2005), “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль (2011) баталж, “Зар сурталчилгааны тухай” хууль, “Харилцаа холбооны тухай” хууль зэрэг олон арван хуулиар хэвлэл мэдээллийн харилцааг зохицуулсан. “Хэвлэлийн эрх чөлөөний тухай” хуулиар бүх хэлбэрийн цензурыг хориглосон байдаг.

Нэр төр гутаахтай холбоотой зүйл заалтууд Иргэний хууль, Эрүүгийн хууль, сонгуулийн бүх шатны хуулиудад бий. Тухайлбал, 2012 онд батлагдсан Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэр төр гутаахтай холбоотой хатуу заалтууд (33.5.4, 33.7.12, 33.11) орсон бөгөөд сонгуулийн үеэр өргөн нэвтрүүлгийн агуулгад хяналт тавих үүргийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ)-т ногдуулж, тэдний дүгнэлтээр хууль зөрчсөн радио, телевизийн үйл ажиллагааг гурван сарын хугацаагаар зогсоохоор хуульчилсан нь Засгийн газрын цензурыг эргээд бодитой болгосон билээ. Үүнд, гар утас, мэдээ, мэдээллийн сайтууд ч хамрагдаж буй. Иргэний хуулийн дагуу зохиогч буюу сэтгүүлч мэдээлэл үнэн болохыг нотлох ёстой.

2011 оноос хойш Засгийн газар уламжлалт болон цахим хэвлэл мэдээлэлтэй холбоотой бодлогын гол баримт бичгүүдийг баталж, Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ноос “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага”, “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага”, мөн өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл авах, техникийн нөхцөлүүдийг зохицуулах хэм хэмжээ тогтоосон гэх мэт 30 гаруй дүрэм журам батлан мөрдөж эхэлсэн юм. Үүнээс хойш ХХЗХ нь анх удаа агуулгын зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх болсон билээ.

Засгийн газар 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай 01 тоот тогтоол, үүнд үндэслэн ХХЗХ “Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам”-ыг 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдөр 05 тоот тогтоолоор тус тус баталсан юм.

Дээр дурдсан бичиг баримтууд, Засгийн газрын тогтоол нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, олон улсын хуулийн хэм хэмжээтэй зөрчилдөж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буй тухай дотооддоо олон удаа хэлэлцэж, санал бодлоо хуваалцсан боловч үр дүнд хүрэхгүй байгаа нь харамсалтай.

## **В. Асуудлууд**

### **В.1. Цахим эрх чөлөө ба нэрээ нууцлах эрх**

Бүртгэл ба шүүлтүүр

Үзэл бодолтой байх эрх, илэрхийлэх эрх чөлөөний зарчмууд цахим хэвлэл мэдээлэлд ч үйлчлэх ёстой. Гэтэл “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага”-ын 7.1 дэх хэсэгт заасны дагуу хэрэглэгчдийн хандалтын дундаж тоо нь нэг сарын туршид өдөрт 3000-аас давсан тохиолдолд тухайн цахим хуудас ХХЗХ-д бүртгүүлж, 7.3 дахь хэсэгт зааснаар “...шүүлтүүр програм заавал ашиглах”-ыг цахим хуудас эрхлэгчдэд үүрэг болгосон байдаг.

Шүүлтүүрийн <http://www.happywebs.mn> дэх программд кирилл (86 үг), латинаар (22 үг) галигласан нийт 108 хориотой үг багтдаг. Тухайлбал, хэрэв хэрэглэгч латинаар галигласан sex, terrorist гэсэн үгийг сэтгэгдэл бичихдээ хэрэглэвэл од (\*\*\*) болон хувирна.

Мэдээ, мэдээллийн цахим хуудсыг бүртгэх, шүүлтүүр хэрэглэх нь Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын хуулийг зөрчсөн үйлдэл гэж үзэж байна.

## Нэрээ нууцлах эрх

Дээр дурдсан Засгийн газрын 01 тоот тогтоолд цахим хуудас дахь сэтгэгдлийг системээс нягтлан шалгах боломж олгох “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийг ТЕГ-ын тусламжтай боловсруулж, гүтгэн доромжилсон, садар самуунд уруу татсан, заналхийлсэн агуулга бүхий сэтгэгдэл бичсэн этгээдийг тодруулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулахыг Хууль зүйн сайдад үүрэг болгожээ. Тогтоолыг дагаж гарсан журам нь интернэтийн болон үүрэн телефоны үйлчилгээ эрхлэгч хувийн компаниудад төрийн байгууллагын хүсэлтээр хууль зөрчсөн гэх иргэдийг илрүүлэхэд туслан, тухайн этгээдийн талаарх мэдээлэл цуглуулах үүрэг ногдуулсан байна.

Монгол Улсад шүгэлдэгч болон сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах хууль байхгүй, сэтгүүлчдийн нууц нэр ашиглахыг хориглох хандлага давамгайлж буй. Тухайлбал, ХХЗХ-ноос хүлээлгэсэн үүргийн дагуу үйлчилгээ эрхлэгчид хэрэглэгчийн үүсгэсэн сэтгэгдэл дээр интернэт хаягийг (IP address) нийтэд харагдахуйцаар байрлуулж байна.

## Агуулгын зохицуулалт ба цензур

ХХЗХ нь өргөн нэвтрүүлэг, цахим хуудас, контент агрегатор, контент нийлүүлэх үйлчилгээ эрхлэгчдийн агуулгад хяналт тавьдаг. Хуулиар хориглосон агуулга нь “шашны харгис номлол”, “садар самуун” гэх мэт хэт ерөнхий томъёологдсон, хэт өргөн хүрээтэй, нарийвчилсан тодорхойлолт байхгүй. Хяналтыг Цагдаагийн Ерөнхий газар, Оюуны өмчийн газар, ШӨХТГ зэрэг төрийн эрх бүхий байгууллага тавих ба тэдгээрийн мэдэгдэл, захидалд үндэслэн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааг зогсоох эрхийг ХХЗХ эдэлдэг.

2012 оноос хойш ХХЗХ зохиогчийн эрхийг зөрчсөн гэсэн үндэслэлээр 172 цахим хуудасны Монгол Улсаас хандах хандалтыг зогсоожээ. ХХЗХ нь эдгээр сайтын жагсаалтыг [www.black-list.mn](http://www.black-list.mn) сайтад байрлуулсан байна.

Мэдээ, мэдээллийн цахим хуудсыг хаах нь гагцхүү зохиогчийн эрхтэй холбоотой бус, цензурын шинжтэйг мэдээний цахим хуудас Монгол Улсын Ерөнхий сайдын “Хаан жимс” компанийг шүүмжилсэнтэй холбоотой сүүлийн хэрэг явдал харуулав. Уг нь ХХЗХ-ны журмаар вэбсайтын үйл ажиллагааг зогсоохоос өмнө энэ тухай урьдчилан мэдэгдэж, сануулах ёстой.

2014 оны 7 дугаар сарын 3-ны өдөр [amjilt.com](http://amjilt.com) вэбсайт “Ерөнхий сайдын “Хаан жимс” амралтын газар Туул гол руу бохироо асгаж байна” гарчигтай сурвалжилгыг гэрэл зургаар баримтжуулан байршуулсны маргааш нь ХХЗХ-ны албан тушаалтан эмэгтэй вэбсайтын удирдлага руу утасдан “Хаан жимс” амралтын газрын гомдлын дагуу ярьж байна. Мэдээллээ устга, залруулга хий, тэгэхгүй бол цагийн дараа хандалтыг хаана” гэж ярьснаас хойш гурван цагийн дараа Монгол Улсаас тус вэбсайт руу хандах хандалтыг хаасан байна. Тус вэбсайтын үйл ажиллагааг өдгөө хүртэл зогсоосон хэвээр байна<sup>9</sup>.

Цахим хуудсыг хаасан үйлдлийг буруушаан дотоодын хэвлэл мэдээллийн төрийн бус байгууллагууд эсэргүүцэл илэрхийлж, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)<sup>10</sup> хэвлэлийн мэдээ гаргасны дараа “Хаан жимс” компани нэг цагийн захиалгат нэвтрүүлгийг телевизийн сувгуудаар зэрэг дамжуулав. Энэ нь олон нийтийн үнэн бодит мэдээлэл авах эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг ноцтой зөрчсөн үйлдэл болсныг харуулж байна.

<sup>9</sup> <http://globeinter.org.mn/?cmd=Record&id=1131&menuid=367>

<sup>10</sup> <http://www.osce.org/fom/121076>

## **ХХЗХ-ны хараат бус байдал ба илэрхийлэх эрх чөлөөний хууль ёсны хязгаарлалт**

ХХЗХ нь өргөн нэвтрүүлгийн давтамж олгох, тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох эрхтэй, энэ үйл явц ил тод бус, олон нийтийн оролцоо муу. Олон улсын хэм хэмжээний дагуу зохицуулах байгууллага төрөөс хараат бус байх ёстой, үндэсний хууль тогтоомжид ч мөн хараат бус байна гэж заасан боловч хэрэг дээрээ Засгийн газраас ХХЗХ-нд тавих хяналт байсаар байна. Энэ байгууллага бүтцийн хувьд Засгийн газрын агентлаг болох Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын харьяа, Ерөнхий сайд дарга, гишүүдийг томилж, чөлөөлдөг, ажлаа Засгийн газарт тайлагнадаг ба долоон гишүүн нь бүгд төрийн байгууллагын төлөөлөл байна.

Монгол Улсад өргөн нэвтрүүлгийн тухай тусдаа хууль байхгүй тул дотоодын дүрэм журмаар нарийвчилсан зохицуулалтыг хийж байна. Ингэхдээ тогтоосон хязгаарлалтууд нь 19-р зүйлд зааснаар хуулиар тогтоох, зайлшгүй байх, хэм хэмжээндээ байх зэрэг хэм хэмжээ, шалгуурт нийцээгүй тул илт зөрчилтэй. Түүнчлэн Засгийн газрын 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-д тусгагдсан “хуулиар тусгайлан олгогдсон хэм хэмжээнд нийцсэн байх”, “хуульд заагаагүй үүргийг шинээр бий болгож, хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх”, “хариуцлага хүлээлгэхгүй байх”, “нөлөөллийн үнэлгээ хийх” зэрэг заалтыг илт зөрчсөн гэж үзэж байна. Хэм хэмжээний актууд нь Хууль зүйн яамны нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байх ёстой ч ХХЗХ-ны “нөхцөл шаардлагууд” гэх зохицуулалтын дүрэм журмууд нь нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй<sup>11</sup> ажээ. Тэдгээрийг үндэслэн агуулга, техникийн нөхцөлийн хяналт, шалгалт хийж, энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрхийг зогсоох, түдгэлзүүлэх, мөн цахим хэвлэл мэдээллийг боомилоход ашиглаж байгаа нь Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг зөрчиж байна.

### **Зөвлөмж**

1. Засгийн газрын 2013 оны 01 тоот тогтоолыг хүчингүй болгож, үзэл бодлыг хянах төрийн хяналтын системийг халах
2. ХХЗХ-ны “нөхцөл, шаардлага”, дүрэм журмуудыг хүчингүй болгох
3. ХХЗХ-ны хараат бус байдлыг бүрэн хангах, олон нийтийн оролцоо, хяналт бий болгох, ил тод байдлыг хангах, Хорооны гишүүдийг Засгийн газраас томилж, чөлөөлдөг, тайлагнах тогтолцоог халах чиглэлээр зохих хуулиудад өөрчлөлт оруулах
4. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоохгүй байх, бүртгэл, шүүлтүүр хэрэглэх, тусгай зөвшөөрөл олгох явдлыг зогсоох
5. Агуулгад тавих хязгаарлалтуудыг 19-р зүйлийн зарчимд нийцүүлэн, холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах

## **В.2. Нэр төр гутаахтай холбоотой Эрүүгийн хуулийн зүйл заалтыг ашиглаж буй нь**

Монгол Улсын Эрүүгийн хуулиар доромжлох (110 дугаар зүйл), гүтгэх (111 дүгээр зүйл)-ийг гэмт хэрэгт тооцон, өндөр хэмжээний мөнгөн дүнгээр торгох, зургаан сар хүртэл баривчлах, 2-5 жил хүртэл хугацаанд хорих ялаар шийтгэхээр хуульчилсан нь

<sup>11</sup> ХЗЯ-ны 2014.08.29-ний өдрийн 4/3496 тоот албан бичиг

цензурыг өөгшүүлж байна. Төрийн албан тушаалтнууд Эрүүгийн хуулийг мэдээлэгч (шүгэлдэгч), сэтгүүлчийн нууц эх сурвалжийг илчлүүлэх, далайлган сүрдүүлэх зорилгоор ашиглаж байна.

Чингэлтэй дүүргийн шүүх Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийн гомдлоор “Тэргүүн” сонины эрхлэгч болон тус сонины сэтгүүлчид 20 гаруй сая төгрөгийн торгуулийн ял ногдуулж, торгох ялаас зайлсхийвэл 3 жил хүртэл хугацаагаар хорих ялаар солихоор шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүх ялыг хэвээр баталж, Дээд Шүүх сонины эрхлэгчид ногдуулсан торгуулийн хэмжээг 7 сая гаруй төгрөг хүртэл бууруулж, сэтгүүлчид ногдуулсан 7 160 400 төгрөгийн торгуулийн хэмжээг хэвээр үлдээжээ<sup>12</sup>.

Эрүүгийн хуулийн нэр төр гутаахтай зүйл заалт олон нийтийн сүлжээ хэрэглэгчдэд ч хүндээр тусах боллоо.

2014 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Зам, тээврийн сайд А.Гансүхийн гомдлын дагуу жиргээч Ц.Батыг Эрүүгийн хуулийн 111.2-т заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон анхан шатны шүүхээр 3 сар, 10 хоногийн баривчлах ялаар шийтгэв. 2014 оны 9-р сарын 9-ний өдрийн давж заалдах шатны шүүх хурлын шийдвэрээр хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж, Ц.Батыг батлан даалтад гаргажээ<sup>13</sup>.

Глоб Интернэшнл төвийн бүртгэлээр 2005-2012 онд Эрүүгийн хуулийн дагуу хэрэг үүсгэсэн 27 тохиолдол байсан бол 2013-2014 онд 13-д хүрсэн байна. Эдгээр бүх хэрэгт гомдол гаргагч нь эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн байгууллага байна.

Хууль зүйн яамны санаачлан УИХ-д өргөн барьсан “Гэмт хэргийн тухай” хуулийн төсөлд нэр төр гутаахыг эрүүгийн хэргээс халсан нь сайшаалтай. Хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд УИХ энэ заалтыг эргэн нэхэж болзошгүй гэдэгт санаа зовниж байна.<sup>10</sup>

## **Зөвлөмж**

1. Гүтгэлэг, доромжлолыг Эрүүгийн хуулиас халах санаачилгыг сайшаахын сацуу Засгийн газар үүндээ тууштай байж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэх улс төрийн хүсэл зориггоо харуулах, манлайлах
2. Нэр төр гутаахтай холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэхдээ олон улсын хуулийг ашиглах, 19-р зүйл, НҮБ-ын Хүний эрхийн хорооны тайлбар, олон улсын бусад хэм хэмжээний талаар хуульч, шүүгч, өмгөөлөгч, прокурорын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх
3. Иргэдийн хувийн нууцыг хамгаалах, нэрээ нууцлах эрх, нууц нэр ашиглах эрхийг баталгаажуулах
4. Шүгэлдэгч, сэтгүүлчийн нууц эх сурвалжийн хуулийн хамгаалалт бий болгох

<sup>12</sup> <http://globeinter.org.mn/?cmd=Record&id=1074&menuid=367>

<sup>13</sup> <http://www.osce.org/fom/122969>